



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Халхгол сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2021/09/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга

бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар



## Агуулга

---

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	8
3. Аудитын тайлан .....	9
3.1. Ерөнхий зүйл .....	9
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй .....	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	9
3.4. Материаллаг байдал .....	10
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	10
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	11
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	11
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	12
3.9. Аудитын илрүүлэлт.....	12
Залруулсан алдаа .....	12
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	12
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	12
4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	13



## 1.Хараат бус аудиторын дүгнэлт



### ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.24 № 206  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХАЛХГОЛ СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА Л.ОНОН ТАНАА

### АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халхгол сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Халхгол сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Халхгол сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээр 94.0 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.



### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,409,500.00</b>	<b>2,248,405.00</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	1,409,500.00	2,248,405.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	1,409,500.00	2,248,405.00
35410	Бичиг хэргийн материал		
35420	Аж ахуйн материал	1,409,500.00	2,248,405.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,336,250.20</b>	<b>29,179,955.75</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	6,336,250.20	29,179,955.75
391	Газар		
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	6,336,250.20	29,179,955.75
39203	Авто-тээврийн хэрэгсэл	25,000,000.00	45,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(25,000,000.00)	(35,833,333.35)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	2,586,000.00	5,867,886.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,776,250.00)	(329,934.60)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,560,000.00	24,399,829.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8,033,499.80)	(9,924,491.30)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>7,745,750.20</b>	<b>31,428,360.75</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>7,745,750.20</b>	<b>31,428,360.75</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	7,745,750.20	31,428,360.75
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	36,898,407.46	36,898,407.46
51101	Өмч: - төрийн	36,898,407.46	36,898,407.46
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	(30,263,230.59)	(6,580,620.04)
51210	Өмнөх үеийн үр дүн	(30,263,230.59)	(30,263,230.59)
51220	Тайланг үеийн үр дүн	-	23,682,610.55
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,110,573.33	1,110,573.33
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>7,745,750.20</b>	<b>31,428,360.75</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>90,435,900.00</b>	<b>92,662,553.33</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	-	<b>29,046,953.33</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	-	29,046,953.33
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	29,046,953.33
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		29,046,953.33
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>90,435,900.00</b>	<b>63,615,600.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	89,435,900.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	89,435,900.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,000,000.00	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	1,000,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	-	62,615,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	62,615,600.00



2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>91,783,899.80</b>	<b>68,979,942.78</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>91,783,899.80</b>	<b>68,979,942.78</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	63,337,899.80	68,817,249.78
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	36,147,195.89	40,510,627.00
210101	Үндсэн цалин	33,948,395.89	32,978,827.00
210104	Урамшуулал	2,198,800.00	7,531,800.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	4,115,804.11	4,122,300.00
210201	Тэтгэврийн даатгал	2,783,828.89	2,900,900.01
210202	Тэтгэмжийн даатгал	332,993.80	305,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	266,395.04	244,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	66,598.76	61,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	665,987.61	610,700.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8,781,700.00	10,233,000.00
210401	Бичиг хэрэг	1,000,000.00	844,000.00
210402	Тээвэр, шатахуун	7,521,700.00	7,727,000.00
210403	Шуудан, холбоо, ингернэтийн төлбөр	-	300,000.00
210404	Ном, хэвлэл	260,000.00	195,000.00
210408	Бараа материал ақталсны зардал	-	1,167,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,723,800.00	6,500,000.00
210604	Урсгал засвар	1,723,800.00	6,500,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	9,244,100.00	1,677,200.00
210702	Дотоод албан томилолт	1,015,000.00	900,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	8,229,100.00	777,200.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	137,300.00	656,780.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	160,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	60,000.00	240,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	234,680.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,300.00	22,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3,187,999.80	5,117,342.78
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,340,000.00	920,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,847,999.80	4,197,342.78
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	28,446,000.00	162,693.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	28,446,000.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28,446,000.00	-
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	162,693.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	162,693.00
3	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(1,347,999.80)</b>	<b>23,682,610.55</b>
4	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	-
5	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(1,347,999.80)</b>	<b>23,682,610.55</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>90,435,900.00</b>	<b>63,615,600.00</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>90,435,900.00</b>	<b>63,615,600.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,000,000.00	1,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,гүүнгэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,000,000.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	89,435,900.00	62,615,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	89,435,900.00	62,615,600.00



Халхгол сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>90,435,900.00</b>	<b>63,615,600.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>90,435,900.00</b>	<b>63,615,600.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>61,989,900.00</b>	<b>63,452,907.00</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	36,716,200.00	40,510,627.00
210101	Үндсэн цалин	33,517,400.00	32,978,827.00
210104	Урамшуулал	3,198,800.00	7,531,800.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	3,546,800.00	4,122,300.00
210201	Тэтгэврийн даатгал	2,280,100.00	2,900,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	315,100.00	305,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	255,000.00	244,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	63,300.00	61,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	633,300.00	610,700.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8,781,700.00	9,066,000.00
210401	Бичиг хэрэг	1,000,000.00	844,000.00
210402	Тээвэр, шатахуун	7,521,700.00	7,727,000.00
210403	Шуудан, холбоо, интернэгийн төлбөр	-	300,000.00
210404	Ном, хэвлэл	260,000.00	195,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,723,800.00	6,500,000.00
210604	Урсгал засвар	1,723,800.00	6,500,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	9,244,100.00	1,677,200.00
210702	Дотоод албан томилолт	1,015,000.00	900,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	8,229,100.00	777,200.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	137,300.00	656,780.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	160,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	60,000.00	240,000.00
210803	Даатгалын үйлчилгээ		
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	234,680.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,300.00	22,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,840,000.00	920,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,840,000.00	920,000.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>28,446,000.00</b>	<b>162,693.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	28,446,000.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28,446,000.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
2133	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	162,693.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	162,693.00
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-
9	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
10	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	36,898,407.46	1,110,573.33	(28,915,230.51)	9,093,750.28
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(0.28)	(0.28)
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	36,898,407.46	1,110,573.33	(28,915,230.79)	9,093,750.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(1,347,999.80)	(1,347,999.80)
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	36,898,407.46	1,110,573.33	(30,263,230.59)	7,745,750.20
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	36,898,407.46	1,110,573.33	(30,263,230.59)	7,745,750.20
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	36,898,407.46	1,110,573.33	(30,263,230.59)	7,745,750.20
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
D08	Тайлант үеийн үр дүн			23,682,610.55	23,682,610.55
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	36,898,407.46	1,110,573.33	(6,580,620.04)	31,428,360.75



## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	62,615,600.00	62,452,907.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	62,615,600.00	62,452,907.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	62,615,600.00	62,452,907.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	40,511,600.00	40,510,627.00
210101	Үндсэн цалин	32,979,800.00	32,978,827.00
210104	Урамшуулал	7,531,800.00	7,531,800.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	4,122,300.00	4,122,300.00
210201	Тэтгэврийн даатгал	2,900,900.00	2,900,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	305,300.00	305,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	244,300.00	244,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	61,100.00	61,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	610,700.00	610,700.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8,131,000.00	8,066,000.00
210401	Бичиг хэрэг	571,000.00	571,000.00
210402	Тээвэр, шатахуун	7,000,000.00	7,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	300,000.00	300,000.00
210404	Ном, хэвлэл	260,000.00	195,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,500,000.00	6,500,000.00
210604	Урсгал засвар	6,500,000.00	6,500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,677,200.00	1,677,200.00
210702	Дотоод албан томилолт	900,000.00	900,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	777,200.00	777,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хур</b>	673,500.00	656,780.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийглэг ажил үйлчилгээний	176,800.00	160,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	240,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	234,700.00	234,680.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,000,000.00	920,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00	920,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	62,615,600.00	62,615,600.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	62,615,600.00	62,615,600.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	62,615,600.00	62,615,600.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,000,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,000,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,000,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,000,000.00
210401	Бичиг хэрэг	273,000.00
210402	Тээвэр, шатахуун	727,000.00
	Мөнгө, түүнгэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнгэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-



### **3. Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Халхгол сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Л.Онон танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 09-нөөс 2021 оны 02 дугаар сарын 15-ны хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах хариуцаж хэрэгжүүлэв.

Халхгол сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 02/01 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Халхгол сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сум, дүүргийн Хурал нь Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, яам, агентлаг, дээд шатны Хуралд болон төрийн эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтанд хуулиар харьяалуулснаас бусад тухайн нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн болон зохион байгуулалтын ямар ч асуудлыг хэлэлцэж бие даан шийдвэрлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Халхгол сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү, хяналт аудитын алба 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Халхгол сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.



### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 68,979.9 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 1,379.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Халхгол сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23,682.7 мянган төгрөгөөр буюу 4 дахин өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	1,409.5	2,248.4	838.9
Үндсэн хөрөнгө	6,336.2	29,180.0	22,843.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>7,745.7</b>	<b>31,428.4</b>	<b>23,682.7</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	7,745.7	31,428.4	23,682.7
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>7,745.7</b>	<b>31,428.4</b>	<b>23,682.7</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 0 төгрөг байна.

Авлага дансны үлдэгдэл 0 төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 2,248.4 мянган төгрөг болж 838.9 мянган төгрөгөөр өссөн нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай аж ахуйн материалыг худалдан авсантай холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 29,180.0 мянган төгрөг болж 22,843.8 мянган төгрөгөөр өссөн нь Шинэ сум байгуулагдсантай холбоотой Ерөнхий сайдын багцаас хөрөнгө оруулалт хийгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь хандиваар 20,000.0 мянган төгрөгийн авто тээврийн хэрэгсэл, шинэ сум байгуулагдсантай холбоотой Ерөнхий сайдын багцаас хөрөнгө оруулалтаар 16,207.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшлоор тус тус нэмэгдсэн байна. Үндсэн хөрөнгө акталсан 2,086.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгийн дансанд гүйлгээ хийгдээгүй байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 0 төгрөг байна.



Урт хугацаат өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 31,428.4 мянган төгрөг болж 23,682.7 мянган төгрөгөөр өссөн нь хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.

Халхгол сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 2,226.7 мянган төгрөгөөр буюу 2.4 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 22,803.9 мянган төгрөгөөр буюу 24.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зочин хүлээн авах, тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардлууд байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 26,615.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 26,615.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг хэвээр баталсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 62,615.6 мянган төгрөгийн төсөв баталснаас 62,615.6 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 62,615.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 62,615.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 62,615.6 мянган төгрөг буюу 100 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 1,0 сая төгрөгийн орлогыг авч гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд зарцуулсан байна.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.



Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс байршуулсан боловч ИТХ-ын 2020 оны 25 дугаар тогтоолоор хөрөнгийн орлогод авсан Алтай группээс хандивласан 20.0 сая төгрөгийн автомашин, 36 дугаар тогтоолоор шинэ сум байгуулагдсантай холбоотой УТХО /ЕС-ын багц/ үнэ төлбөргүй ирсэн 16,207,715 төгрөгийн тоног төхөөрөмжийг мэдээлээгүй байна.

### **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

### **3.9. Аудитын илрүүлэлт**

Аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоос өөр алдаа зөрчил илрээгүй болно.

#### **Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулга хийгдээгүй.

#### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 36,207.7 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Хөрөнгийн 36,207,7 мянган төгрөгийн орлогыг [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.1 дэх "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал гараагүй.



#### 4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<b>Халхгол сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
2020			ДОА-2021/09/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Халхгол сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал</b>		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Хөрөнгийн орлогыг мэдээллийг <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> цахим хуудсанд байршуулаагүй.	36,207.7	Албан шаардлага	Нягтлан бодогч	М.Ариунзул
	<b>ДҮН</b>	<b>36,207.7</b>			